



Д.Хүчэгж
Засагчийн хэргийн
хамрх, хяналтуу ажх.

**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

Дугаар 002.05.22.

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/269

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд сууринсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоог нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоог зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан мэргэжил арга зүйгээр ханган, эмнэлгийн үндсэн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ)-т, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдах ажиллагсдын ажлын цагийг зохицуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үзлэгийн хамралт, үр дүнг хагас жил тутамд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (А.Түвшинжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дүгээр сарын 22.-ны өдрийн
A/269 дугаар захирамжийн хавсралт

ХҮН АМЫН НАС, ХҮЙС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРСДЭЛД СУУРИЛСАН
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ,
ОНОШИЛГООГ НЭГДСЭН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТААР
ХАНГАЖ АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга : А.Түвшинжаргал (Аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч)
- Гишүүд: А.Бумансор (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Н.Бямбацэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
- О.Батцэнгэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Б. Баасансүрэн (Баян-Өндөр сумын Засаг дарга)
- Б.Зоригтбаяр (Жаргалант сумын Засаг дарга)
- Д.Өнөбат (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Нийгмийн харилцааны хэлтсийн дарга)
- О.Ариунгэрэлт (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
- Д.Оюунтунгалааг (Мэргэжлийн хяналтын газрын Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч)
- Х.Саранчимэг (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга)
- П.Хишгээ (Эрүүл мэндийн газрын Эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
- А.Баярхүү (Эрүүл мэндийн газрын Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)
- Б.Мөнх-Эрдэнэ (Баян-Өндөр сумын Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн)
- Ц.Наран-Эрдэнэ (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал)
- Б. Нямхүү (Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн IT инженер)
- В.Цэндхүү (Мэдээллийн төвийн ахлах ажилтан бөгөөд аймгийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч)
- Нарийн бичгийн дарга: Д.Сүхээ (Эрүүл мэндийн газрын дарга)